



# СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

№69 /283/

2022.04.08

Цаг үе, үйл явдал

## ТӨРИЙН ОДОН, МЕДАЛИАР ШАГНАЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Батлан хамгаалах салбарт үр бүтээлтэй ажиллаж, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэн бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж буй офицер, ахлагч, ажилтан албан хаагч, ахмадуудыг төрийн одон, медалиар шагналаа. Шагналыг Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг нар гардуулсан юм.

Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор ЗХЖШ-ын Материал, техникийн газрын Орон сууцны хэлтсийн дарга хурандаа Ц.Ганбат, Кибер аюулгүй байдлын цэргийн командлалын хамтын ажиллагааны офицер дэд хурандаа Д.Мөнхбат, зэвсэгт хүчний

350 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Б.Ууганбаяр, "Алтангадас" одонгоор Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн ахмад ажилтан Х.Элбэг, Г.Алагаа, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн ахмад ажилтан У.Даваа, Цэргийн хүндэт медалиар Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн дайчилгааны ахлах офицер дэд хурандаа Н.Цэгмид, миномётын батареины ахлагч ахлах ахлагч З.Будбаяр, харуулын салааны ахлах харуулчин ахлагч Ц.Насанбаяр, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн соёл, спортын төвийн дарга, ахмад Б.Энх-Амгалан, дайчилгааны нууцын хэрэг хөтлөгч сургагч ахлагч Ж.Одгэрэл, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 104 дүгээр тусгай ротын удирдах байрын жижүүр

ахлах ахлагч А.Алтаншагай, 322 дугаар тусгай ротын удирдах байрын жижүүр ахлах ахлагч Д.Энхболд, Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн авто техникийн нярав-засварчин ахлах ахлагч У.Дэлгэрсайхан, Хөдөлмөрийн хүндэт медалиар Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн жолооч Д.Ганбаатар нар энгэрээ цооллоо. Мөн өдөр төрийн цэргийн байгууллагуудаас бэлтгэл чөлөөнд гарсан Баянзүрх дүүргийн ахмадуудад Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медаль гардууллаа. Ёслолын ажиллагаанд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, Э.Бат-Амгалан, тус дүүргийн Засаг дарга Н.Баярмөнх, ИТХ-ын дарга И.Баяр, БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын дарга хурандаа

С.Ванчинхүү, Цэргийн штабын дарга дэд хурандаа О.Энх-Амар болон бэлтгэл чөлөөнд гарсан ахмадууд оролцлоо.

Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медалиар МЦНХ-ны Баянзүрх дүүрэг дэх салбар зөвлөлийн гишүүн чөлөөнд байгаа хурандаа Б.Баянмөнх, чөлөөнд байгаа дэд хурандаа Б.Батмөнх, чөлөөнд байгаа цагдаагийн хурандаа Б.Энх-Амгалан, чөлөөнд байгаа хурандаа Г.Мөнхдөл, чөлөөнд байгаа дэд хурандаа Г.Жаргалсайхан, бэлтгэл дэд хурандаа Г.Ганзориг нарын 50 ахмадыг шагнасан юм.


Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр шагнагдсан бүрэлдэхүүнд хандан баяр хүргэж, ажлын амжилт, амьдралд нь аз жаргал эрүүл энхийг хүсэн ерөөв.

## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АЛБА ХААГЧДАД ЦАХИМААР ХИЧЭЭЛ ОРОВ

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын офицеруудын заах аргын цугларалтад ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын мэргэжилтэн дэд хурандаа А.Батсүх, ахмад Д.Баасандорж нар "Штабын бэлтгэл

сургалт", "Мэдээлэл харилцаа холбооны технологи ба зайн сургалт" сэдвээр хичээл орж туршлага сургамжаа солилцлоо. Тус сургалтад нийт ОБЕГ-ын УАБ-ын 40 офицер хамрагдсан юм.

Ахмад Д.БААСАНДОРЖ



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,272,557 /69.9%!	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,174,840 /66.8%!	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,033,548 31,8% 116,029 /3,6%!
НИЙТ БАТЛАГДСАН 8435 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 0	ЭДГЭРСЭН 8314

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

**Тохиолдол**  
Нийт: 494,215,914

**Эдгэрсэн**  
Нийт: 429,807,346

**Нас барсан**  
Нийт: 6,183,655

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 13	☁️ -1
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 40	☁️ 25

## ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,130.00	3,170.0
EUR 🇪🇺	3,480.0	3,550.0
CNY 🇨🇳	499.00	501.00
RUB 🇷🇺	34.00	36.50
JPY 🇯🇵	27.00	27.70
KRW 🇰🇷	2.62	2.70

## ЗУРХАЙ

2022.04.08 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 7/

**ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
06.17-19.31  
**Барилдлага:**  
Идэр  
**Шүтэн барилдлага:**  
Сансар  
**Суудал:** Хий

Энэ өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд зөвгө сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лусыг тахиж, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Сэтгэлд сөвтэй газар очих, газар хагалах, ус булгийн эх малтах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

**ЭМД** Зүүл мөнхийн гаалганы шимтгэлийг нь **ТӨР ХАРИУЦАН ТӨЛӨХ ҮРГЭД**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2% -иар

- Тэтгэвэрээ өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн
- Нийгмийн халамжийн гэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай ердийн гишүүн иргэн
- Хүүхдээ 2 дугаар сар 31 нас хүртэл нь өсгөн бэлтгэл хийж эхлэх үйлдэгч
- Хүндэтгэл цэргийн албан хаагч
- Ил эрэлт байгаа иргэн

сая 8,400Т 0 - - - - - 100,800Т жилд

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1% -иар

- 0-18 насны хүүхэд

сая 4,200Т 0 - - - - - 50,400Т жилд

Та өөрийн ЭМД-ын шимтгэл төлөхийн мэдээлэлд байгаа гэрээгээ, холбооны шалтгаан болонгой WWW.EMD.GOV.MN

Цахим шууданд

**БХЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН СУРГАЛТАД ХАМРАГДАВ**



байгууллагууд хамрагдах юм. Сургалтаар Батлан хамгаалах салбарын сахилга дэг журам, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр БХЯ-ны холбогдох албан тушаалтнуудын лекц хичээлээс гадна урилгаар Авилагтай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар Н.Батчулуун, М.Жамъянцоожил нар оролцож авлига хээл хахуул, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр лекц уншлаа.

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн ажлын алба, БХЯ-ны СБТГ-аас Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журам болон ёс зүйн мэдлэг олгох цуврал сургалтыг БХЯ-ны харьяа байгууллагын бие бүрэлдэхүүнд энэ сарын 8, 11-ны өдрүүдэд зохион байгуулж байна. Өнөөдөр тус сургалтад ҮБХИС, "Бөртэ" ТӨААТҮГ, "Бага баян-Энхийн төлөө" цогцолбор төв ТӨААТҮГ-ын бие бүрэлдэхүүн хамрагдаж байгаа бол ирэх даваа гарагт Цэргийн төв эмнэлэг, "Соёмбо

редакц", Батлан хамгаалахын төв архив, ЦДБЭЧ, "Алдар" спорт хороо зэрэг бусад



**ДАЙЧИН ХӨВГҮҮД ЦОГ ЗОЛБООТОЙ, ЭХ ОРНЫ ХИЛ ТАЙВАН БАЙНА**



хүчний 327 дугаар анги, Хилийн цэргийн 0132 дугаар анги болон Зэвсэгт хүчний 338 дугаар ангид алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдаа эргэж цэргийн албаны үйл ажиллагаатай танилцаж Засаг даргын гарын бэлэг болон дайчдын ар гэрээс ирүүлсэн захидал, илгээмжийг гардуулан өглөө. Дайчин хөвгүүд цог золбоотой, эх орны хил тайван байна.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Сүхбаатар аймгийн

хаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 3 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Зэвсэгт

Засаг дарга М.Идэрбат Батлан хамгаалахын сайдтай 2022 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний хүрээнд иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах зорилгоор ажлын хэсэг томилон цэрэг дайчдаа эргэх арга хэмжээг зохион байгууллаа.



Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Б.Аваацогт болон бусад алба

Ахмад Т.СУГАРЖАВ

**ЦЭРГИЙН ГАЛ ТОГООНЫ ШАВ ТАВИХ ЁСЛОЛ БОЛЛОО**



зохион байгуулагдлаа. Ёслолын арга хэмжээнд Дорнод аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа О.Ганзориг, Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн захирагч хурандаа П.Мөнхбат тэргүүтэй төрийн цэргийн байгууллагын удирдлагууд оролцож, баяр хүргэсэн юм.

Зэвсэгт хүчний 327 дугаар анги БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангийнхны алба хаах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд БХЯ, ЗХЖШ, ХЗЦК-аас шат дараатай арга хэмжээг авч

Шав тавих ёслолын эхэнд ангийн захирагч хурандаа Н.Цэцэнхүү хэлсэн үгэндээ "Орчин цагийн Зэвсэгт хүчний 101 жил, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн 25 жилийн ойн хүрээнд алба хаагчдынхаа ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоо маань өнөөдөр бодит ажил болж байгаад захирагчийн хувьд баяртай байна. Манай хамт олон түүхт 25 жилийн ойн хүрээнд 25 бүтээлч ажил өрнүүлнэ" гэсэн юм. Энэхүү бүтээн байгуулалтыг Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн бариллагчдын дайчид гүйцэтгэх юм. Ахмад Э.МӨНХБАЯСАХ

хэрэгжүүлж байна. Үүний нэг бүтээн байгуулалт нь "Цэргийн гал тогоо" юм. Дээд шатны байгууллагуудын дэмжлэгтэйгээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах "Цэргийн гал тогоо"-ны шав тавих ёслол энэ сарын 7-ны билигт сайн өдөр

**"НИЙСЛЭЛИЙН ЦЭРГИЙН ШТАБЫН ТҮҮХЭН ЗАМНАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА" СЭДЭВТ ОНОЛЫН БАГА ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙНА**



Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын 97 жилийн ойг тохиолдуулан "Нийслэлийн Цэргийн штабын түүхэн замнал, цаашдын хандлага" сэдэвт онолын бага хурал өнөөдөр ҮБХИС-ийн Сүбээдэй танхимд зохион байгуулагдаж байна.



Хуралд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Б.Ялалт болон Нийслэл дүүргийн Цэргийн штабын нийт бие бүрэлдэхүүн оролцлоо. Тус хурлаар Цэргийн штабын үүсэл

хөгжил, дайны жилүүдэд гүйцэтгэсэн үүрэг, 1965-2005 онуудад Нийслэлийн цэргийн хэлтэс, штабын бүтэц зохион байгуулалт, гүйцэтгэж байсан ажил үүрэг болон Зэвсэгт хүчний штабын бэлтгэл, сургалтад цэргийн штабын оролцоо зэрэг сэдвээр илтгэл хэлэлцүүлээ. Мөн энэ үеэр ЗХЖШ-ын нэгдүгээр ологч дарга, бригадын генерал С.Ганбямба Нийслэлийн цэргийн штабын бие бүрэлдэхүүнд Зэвсэгт хүчний бодлого үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлт, цаашдын чиг хандлагын талаар илтгэл тавьсан юм.

**27 СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА, БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН ҮҮРЭГ ОРОЛЦОО СЭДЭВТ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА**



Батлан хамгаалахын сайдын Төв аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 27 сумын ЗДТГ-ын дарга, багийн Засаг дарга нартай сургалтыг тус аймгийн Алтанбулаг сумын нутагт байрлах Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийг түшиглэн энэ 07-ний өдөр амжилттай зохион явууллаа. Сургалтын үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын дарга бөгөөд цэрэг татлагын товчооны дарга дэд хурандаа Ц.Хишигсүрэн, Эрүүл мэндийн газрын дарга С.Мөнхтуяа, аймгийн Прокурорын газрын прокурор М.Гансүвд нарын удирдлагууд оролцлоо. Уг сургалтын үйл ажиллагааг аймгийн ЗДТГ-ын дарга бөгөөд цэрэг татлагын товчооны дарга М.Отгонбат нээж үг хэллээ.

Үргэлжлүүлэн Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын даргын баталсан хөтөлбөрийн дагуу Цэргийн штабын танилцуулга, Батлан хамгаалах багц хууль, Цэргийн албаны тухай хууль, Дайчилгааны тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, цэргийн дүйцүүлэх албаны журам, Засгийн газрын тогтоол, Цэргийн бэлтгэл албаны сургалтуудын талаар цэргийн штабын дарга дэд хурандаа Т.Төмөрчөдөр, дайчилгааны офицер хошууч Б.Бадарч, орон нутгийн хамгаалалт сургалтын офицер ахмад С.Солонго нар өөрсдийн үүрэг чиглэлийн дагуу мэдээлэл лекц хичээл орж цаашид 2022 онд хийж хэрэгжүүлэх онцлог ажил арга хэмжээний талаар үүрэг чиглэл өглөө. Мөн Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдал, цаашид Цэргийн бэлтгэл арга хэмжээ сэдвийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газрын дарга С.Мөнхтуяа, Цэргийн бүртгэл цэрэг татлагын тухай хууль, зөрчсөн иргэдтэй хариуцлага

тооцох арга хэмжээний талаар аймгийн прокурорын газрын прокурор М.Гансүвд нар нөхцөл байдлын талаар хуулийн мэдээлэл хийсэн сургалт үр дүнтэй явагдлаа. 2021 онд Батлан хамгаалах бодлого хууль тогтоомжийг орон нутагтаа хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дүнгээр 27 сумын хэмжээнд нэгтгэн дүгнэж Цэрэг татлагын ажил Эрдэнэсант сум, Цэргийн бүртгэлийн Архуст сум, Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогыг Жаргалант сум, Батлан хамгаалах бодлогыг сурталчлах Угтаалцайд сум, Цэргийн бэлтгэл сургалтыг Зуунмод сумууд шалгарч хүндэт өргөмжлөл, албаны хэрэгцээнд зориулж принтерээр шагнаж урамшууллаа. Энэхүү сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын бүрэн хангаж ажилласан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын офицерууд, Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн удирдлага хамт олонд талархал илэрхийллээ. Ахмад С.СОЛОНГО